



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18 дахь заалтууд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21¹.1, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3. дугаар сарын 3.-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн саналыг нэгдүгээр хавсралтаар дэмжсүгэй,
2. Компанийн 2022 оны Бизнес төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт, компанийн бүтэц, зохион байгуулалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан 2022 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн санал, 2022 оны Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигч болон зохих байгууллагад хүргүүлэх, баталгаажуулах ажил зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР

1522010004



**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН САНАЛ**

(мянган төгрөг)

д/д	Үзүүлэлтүүд	2020 оны гүйцэтгэл*	2021 оны		2022 оны төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		хувь	мөнгөн дүн
1	Үйл ажиллагааны нийт орлого:	1 124 667	2 738 833	5 520 926	6 033 833	9%	512 907
1,1	Арилжааны шимтгэл	400 061	1 126 551	3 548 107	3 595 374	1%	47 267
1,2	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	487 952	807 197	1 181 472	2 049 083	73%	867 611
1,3	МІТ ашиглалтын орлого	-	504 023	509 974	-	шинэ	(509 974)
1,4	Бусад	236 654	301 063	281 372	389 376	38%	108 004
2	Үйл ажиллагааны нийт зардал:	2 101 228	2 719 702	2 168 807	3 269 595	51%	1 100 788
2,1	Үйл ажиллагааны зардал	991 933	1 225 482	990 606	2 036 287	106%	1 045 680
2,2	ҮХ элэгдлийн зардал	266 067	316 269	239 905	497 192	107%	257 287
2,3	МІТ ашиглалтын зардал	843 227	1 177 951	938 295	736 116	-22%	(202 180)
3	Үйл ажиллагааны татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/	(976 561)	19 131	3 352 119	2 764 239	-18%	(587 881)
4	Орлогын татвар	1 989	-	168 186	276 424	64%	108 238
5	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	(1 037 795)	19 131	3 183 991	2 487 815	-22%	(696 176)
6	Нийт авлага /цэвэр/	84 131	56 906	97 241	55 267	-43%	(41 974)
7	Нийт өглөг /МІТ төслийн зардал оруулж тооцоноор/	2 193 451	772 900	926 821	276 424	-70%	(650 397)
8	Ажиллагсдын тоо	53	55	53	55	4%	2
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	1,87	0,99	0,39	0,54	38%	0,15
10	Хөрөнгө оруулалт	147 765	176 335	166 540	1 057 830	714%	927 900